

**АЗИЙН БУДДИСТҮҮДИЙН БАГА ХУРАЛ**  
**(Улаанбаатарт болсон АБЭТБХ-ны V Ерөнхий**  
**бага хурал)**

Азийн Буддистүүдийн Энх тайвны бага хурлын V Ерөнхий Бага Хурал «Энх тайван, эв нэгдэл, шударга ёс» гэсэн уриан дор 1979 оны 6-р сарын 16-19-нд Улаанбаатар хотноо амжилттай болж өнгөрлөө.

Тус Ерөнхий бага хуралд Азийн олон орны сая сая буддистүүдийг болон дэлхийн энх тайвны төлөө тэмцэгч шашны болон шашны бус олон улсын байгууллагуудыг төлөөлсөн төлөөлөгч, зочин, ажиглагч 240 гаруй хүн оролцов.

Хуралд Бангладеш, Бутан, Англи, БНУАУ, БНСВУ, Энэтхэг, Кампучи, Лаос, Балба, БНМАУ, ЗХУ, АНУ, Тайланд, Шри Ланка, Япон зэрэг 15 орон, Ази Африкийн Эв Санааны Нэгдлийн Байгууллага, ДЭТЗ, НҮБ, Христосын шашинтны энх тайвны бага хурал, Азийн христосын шашинтны энх тайвны бага хурал зэрэг олон улсын 7 байгууллагын элч төлөөлөгчид оролцлоо.

АБЭТБХ-ын V Ерөнхий бага хуралд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга А. Н. Косыгин, БНСВУ-ын Засгийн газрын ерөнхий сайд Ван Донг, Кампучийн Ардын хувьсгалт зөвлөлийн дарга Хенг Самрин, БНАЛАУ-ын ерөнхий сайдын орлогч Фоуми Воугвичит, ДЭТЗ-ийн дарга Рошем Чандра болон Ази Африкийн эв санааны нэгдлийн байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Абдел-Рахман Эл-Шаркави, Бүх Оросын Үнэн алдарт шашинтны тэргүүн Митрополит Пимен, Тайландын их ламтан Сомдеж Фра Агибавонгсагатанана нар баярын илгээлт ирүүллээ.

АБЭТБХ-ны ерөнхийлөгчийн урилгаар V ерөнхий бага хуралд шарын шашны тэргүүн эрхэмсэг дээд ламтан XIV далай лам Данзанжамц, Японы энх тайвны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, Японы буддийн холбооны ерөнхийлөгч 95 настай ламтан Ничидацу Фужи зэрэг хүндэт зочид оролцож, энх тайвны төлөө буддистуудын тэмцлийг улам хүчтэй болгох нь зөв зүйтэй, цаг үеийн чухал шаардлагатай байгааг тэмдэглэн дэмжиж байв.

Үүсч буй болсон цагаасаа эхлэн Вьетнамын ард түмний баатарлаг тэмцлийг дэмжиж тусласаар ирсэн АБЭТБХ-ын энх тайванч үйл ажиллагаа, энэрэнгүй бодлогыг БНСВУ-ын засгийн газар өндөр үнэлж. АБЭТБХ-ыг «Найрамдлын одон»-гоор шагнасныг БНСВУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдын яамны төлөөлөгчөөс ерөнхийлөгч С. Гомбожавт баяр ёслолын байдалтай гардуулав.

АБЭТБХ-ын V Ерөнхий бага хуралд АБЭТБХ-ын ерөнхийлөгч, номч мэргэн гавж С. Гомбожав Азийн буддистүүдийн энх тайвны хөдөлгөөний түүхэн замнал, одоогийн байдал, цаашдын зорилтын тухай дэлгэрэнгүй үг хэлж, Азийн буддистүүдийн энх тайвны хөдөлгөөн өнгөрсөн 10 жилд гуйвалтгүй өсөн бэхжиж, үйл ажил, үзэл санааны хувьд нэгдэж,

бүтэц зохион байгуулалтын хувьд өргөжиж нягтарсан, энхийг эрхэмлэгч, нэр төртэй олон улсын байгууллага боллоо гэж тэмдэглэв.

Мөн АБЭТБХ-ын V Ерөнхий бага хурлаас (1976) хойшхи хугацаанд АБЭТБХ-аас зохион явуулсан ажлын тухай тайлан илтгэлийг АБЭТБХ-ын ерөнхий нарийн бичгийн дарга профессор Ч. Жүгдэр тавив.

V Ерөнхий бага хурлын 2 комисст АБЭТБХ-ын төв штабын болон үндэсний төвүүдийн тайлан илтгэлээс гадна «Ази дахь олон улсын байдал ба Азийн буддистүүдийн энх тайвны хөдөлгөөний зорилт» (илтгэгч нь Шри Ланкийн лам Индиратана), «Зүүн өмнөд Азийн байдал», (илтгэгч нь Вьетнамын лам Тих Три До), «Зэвсэг хураах асуудал ба Азийн буддистүүдийн энх тайвны хөдөлгөөний зорилт» (илтгэгч нь Японы лам Г. Сато), «Энх тайвны төлөө тэмцэлд Азийн буддистүүдийн хамтын ажиллагаа» (илтгэгч нь Энэтхэгийн лам К. Бакула), «Зүүн өмнөд Азид энх тайван тогтооход олон улсын эв санааны нэгдлийг бэхжүүлэх нь» (илтгэгч нь Вьетнамын лам Тих Мин Нгует) зэрэг илтгэлүүдийг сонсч хэлэлцэв.

Хурлын өмнөхөн Вьетнам, Кампучид айлчилсан АБЭТБХ-ын олон улсын төлөөлөгчид «Вьетнамд хятадын үйлдсэн гэмт хэрэг, Кампучид явуулсан аллага таллага» гэсэн илтгэл, хурлын үеэр гаргасан гэрэл зургийн үзэсгэлэнгээрээ Пол-Пот, Иенг Сарийн харгис бүлэглэлээс Бээжингийн эрх баригчдын ивээл дор Кампучид явуулсан яргалал, хятадуудаас Вьетнамд явуулсан түрэмгийллийн хор хөнөөл, бузар булай үйл явдлыг илчлэн харуулав.

V Ерөнхий бага хурлаас «Ази болон даян дэлхийн буддистүүдэд хандсан Улаанбаатарын уриалга», «АБЭТБХ-ын Ерөнхий бага хурлын ерөнхий тогтоол», «Вьетнам, Лаос, Кампучийн талаархи тусгай тогтоол», «Азийн орнуудын төрийн тэргүүнүүдэд хандсан уриалга», «Албан мэдээ» гэсэн төгсгөлийн баримт бичгүүдийг санал нэгтэй батлав.

Эдгээр баримт бичигт Вьетнамын баатарлаг ард түмэн, Лаос, Кампучийн эх орончдоос байгуулсан түүхэн ялалт, Азийн хөгжиж буй улсуудын үүрэг, нэр хүнд өсөж байгаа, энх тайвны төлөө дэлхий дахины хөдөлгөөн улам өргөн далайцтай болж байгаа зэрэг манай тивд гарч буй нааштай ахицыг тэмдэглэхийн сацуу зэвсэглэлээр хөөцөлдөх явдал улам даамжирч Ази тивд цэргийн түрэмгий эвсэл холбоо, АНУ-ын цөмийн зэвсгийн баазууд оршиж байгаа болон империалист харгис хүчинтэй эвсэн нэгдсэн хятадын эрх баригчдын их гүрний үндсэрхэх, дээрэнгүй, жанжлах бодлогын уршгаар Азийн улс түмнүүдийн энх тайван аюулгүй байдалд ноцтой заналхийлэл урьдын адил байсаар байгааг онцлон тэмдэглэсэн байна.

V Ерөнхий бага хурлын төгсгөлийн баримт бичгүүдэд хятадын эрх баригчдаас БНСВУ-ын эсрэг түрэмгий дайн өдүүлж, БНАЛАУ-ын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, Кампучид ялт хэрэг үйлдсэн, Энэтхэг хятадын хойгийн улсуудын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд аюул занал учруулж байгааг эрс буруушаажээ.

Ийм нөхцөлд бүх нийтийн энх тайван, шударга ёс, хөгжил, хүний эрх, хөгжил дэвшлийн үйлсэд оруулах нэмрээ арвижуулах, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураахын төлөө тэмцэлд улам идэвхтэй оролцож, энх тайвны үйлсийн төлөө үлэмж сонор сэрэмжтэй байх, эв нэгдлээ бэхжүүлэх, энхийг эрхэмлэгч шашны болон шашны бус бусад бүх хүчинтэй хамтран ажиллах, энх тайвны үйлсэд сүсэгтэн олны тэмцэл, санаа бодлыг цаашид тууштай дайчлан чиглүүлэх нь тус хөдөлгөөний гол зорилт, ариун үүрэг хэмээн тодорхойлсон байна.

Хуралд оролцогсад стратегийн давшилтын зэвсэглэлийг хязгаарлах тухай Зөвлөлт-Америкийн шинэ гэрээнд ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Л. И. Брежнев, АНУ-ын ерөнхийлөгч Ж. Картер нарын зурсан тухай мэдээг баяртай хүлээн авч, тус гэрээ энх тайвны чухал ач холбогдолтойг тэмдэглэв.

ГБХ-ын Ерөнхий бага хурал, Кампучийн ард түмнийг туслан, дэмжиж өргөн кампанит ажил өрнүүлэхийг Азийн бүх бүддистүүдэд уриалав.

АБЭТБХ-ын Ерөнхий бага хуралд оролцогсдоос БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалд хариу илгээлт явууллаа. Тэрхүү илгээлтэд БНМАУ-ын Засгийн газар монголын ард түмний шүтэх бишрэх эрхийг ханган хэрэгжүүлэх, энх тайван, хүн ардын аз жаргалын төлөө монголын бүддистүүдийн хөдөлгөөнийг бүх талаар дэмжиж байдгийг сэтгэл ханамжтай тэмдэглээд, Азийн энх тайван, аюулгүй байдал, улс үндэстний эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө тэмцлийн ариун үйлсэд бүх хүч чармайлтаа дайчлах шийдвэр төгс байгаагаа илэрхийлсэн байна.

АБЭТБХ-ын V Ерөнхий бага хурал нь АБЭТБХ-ын дүрмийг хэлэлцэн батлаад 20 хүний бүрэлдэхүүнтэй Гүйцэтгэх Зөвлөлийг шинээр сонгож, АБЭТБХ-ын ерөнхийлөгчөөр номч мэргэн гавж С. Гомбожавыг, дэд ерөнхийлөгчөөр эрхэмсэг ламтан Ш. Мибу (Япон), эрхэмсэг ламтан К. Бакула (энэтхэг), эрхэмсэг ламтан фан Тхе Лонг (Вьетнам) нарыг, Ерөнхий нарийн бичгийн даргаар профессор Ч. Жүгдэрийг тус тус сонгон баталлаа.

Дөрөв хоногийн турш үргэлжилсэн энэхүү бага хурал нь Азийн бүддистүүдийн энх тайвны хөдөлгөөний томоохон түүхэн үйл явдал болж, түүний цаашдын өрнөлтийн шинэ үеийг нээж, АБЭТБХ-ын үйл ажиллагааны хөгжилтийг тодорхойлж, 10 жилд хийсэн ажлаа дүгнэж, хөдөлгөөнийхөө ойрын гурван жилийн хөтөлбөрийг боловсрууллаа.

Ерөнхий бага хурал нэгэн номын нөхдийн бие биеэ ойлгож, харилцан хүндэтгэсэн, эв нэгдэлтэй, ажил хэрэгч, элэгсэг дотно чин сэтгэлийн найрсаг байдалд болж өнгөрлөө.

V Ерөнхий бага хурлынхаа шийдвэрийг биелүүлэн, бүддистүүдийн энх тайвны хөдөлгөөний өмнө тулгарч байгаа ээлжит зорилтуудыг хэрэгжүүлэхэд энхийг эрхэмлэгч бүддистүүд шийдвэр төгс байлаа.

С. Ламчин